



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Идэвхтэй хөдөлгөөн-Зөв хооллолт-Эрүүл ажлын байр” сэдэвт сургалт семинарт явуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 246, 2009 оны 05 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дэргэдэх биеийн тамир, спортын хамтлагуудын арга зүйчдийг мэдээллээр хангах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Идэвхтэй хөдөлгөөн-Зөв хооллолт-Эрүүл ажлын байр” сэдэвт сургалт семинарыг 2013 оны 04 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.
2. Сургалт семинарыг байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалт семинарт шаардагдах 670.000 /зургаан зуун далан мянган/ төгрөгийг нийслэлийн орон нутгийн төсвийн сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.
4. Сургалт семинарыг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны дөрөвдүгээр сарын 18-ны өдрийн
12 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“Идэвхитэй хөдөлгөөн – Зөв хооллолт – Эрүүл ажлын байр”
сэдэвт сургалт семинарын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын хөлс 1 /хоног/ х 8 цаг х 20.000/төг/	160.000
2.	Заал, талбайн хөлс	200.000
3.	Бичиг хэргийн зардал	150.000
4.	Гарын авлага, сурталчилгаа	100.000
6.	Видео бичлэг, зураг, хальс анонс	60.000
ДҮН:		670.000

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны сөрөг үйл сарын 15-ны өдрийн
1/26 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“Идэвхитэй хөдөлгөөн – Зөв хооллолт – Эрүүл ажлын байр”
сэдэвт сургалт семинарын хичээл заах багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|------------------------------------|---|
| 1. Ц.Март | Монголын Гимнастикийн холбооны зөвлөх багш |
| 2. Д.Эрдэнэчимэг
төвийн захирал | НЭМҮ-ний төвийн ЭМ-ийн сургалт судалгааны |
| 3. Д.Энхчимэг
тасгийн эрхлэгч | Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төвийн 9-р |
| 4. Б.Баасанжаргал | ЭМШУИС-ийн эрүүл ба эмгэг физиологийн
тэнхмийн багш, анагаах ухааны доктор |
| 5. Д.Оюунсүвд | Эрүүл мэндийн нэгдлийн хоол зүйч |